



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 4/348

Улаанбаатар хот

Монгол Улсын их сургуульд пост-доктор
ажиллуулах журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь хэсэг, МУИС-ийн Ректоратын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын их сургуульд пост-доктор ажиллуулах журмыг хавсралтаар баталж, 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар), Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (С.Гомбобаатар), Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор (Б.Даваасүрэн), Ахисан түвшний сургуулийн захирал (Ц.Амартайван) нарт даалгасугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ



Ректорын 2025 оны 07 дугаар сарын 01 -ны
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт
1348

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ПОСТ-ДОКТОР АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь (цаашид "Журам" гэх) МУИС-д пост-доктор ажиллуулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Судалгааны их сургууль болох зорилгын хүрээнд МУИС-ийн профессорын судалгааны ажил, төсөл, хөтөлбөрийг дэмжих, залуу судлаачдыг судалгааны ажилд татан оролцуулах, чадавхжуулах, эрдэм шинжилгээний ажлын чанарыг сайжруулах, профессор болон залуу судлаачдын эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд энэ журмын зорилго оршино.
- 1.3. Пост-доктор гэдэгт докторын зэрэг хамгаалсан, тухайн шинжлэх ухааны салбар, судалгааны сэдвийн хүрээнд судалгаа шинжилгээний ажлын өндөр чадавхтай, судалгааны шинэлэг санаа, мэдлэгийг бий болгодог, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлдэг, лабораторийн туршилтыг гүйцэтгэх чадвартай иргэнийг ойлгоно.
- 1.4. МУИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургууль ба судалгааны хүрээлэн болон төвд (цаашид "Судалгааны нэгж" гэх) пост-доктор ажиллуулж болно.
- 1.5. МУИС-д пост-докторыг ажиллуулах үйл ажиллагааг төлөвлөх, батлуулах, хэрэгжилтийг хянах, тайлагнахыг судалгаа хариуцсан нэгж (цаашид "СХН") хариуцан зохион байгуулна.
- 1.6. МУИС-ийн профессор цолтой, эсвэл профессорын зэрэглэлд ажилладаг, эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй үндсэн багш нь Монгол Улсын болон гадаадын харьяат докторын зэрэгтэй иргэнийг, үндэсний болон олон улсын хэмжээний сэдэв бүхий судалгааны ажлын хүрээнд пост-докторыг удирдана.

Хоёр. Тавигдах шаардлага

- 2.1. Пост-доктор дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1 Докторын зэргээ хамгаалснаас хойш 5 жил болоогүй байх;
 - 2.1.2 Пост-докторын ажлын даалгаврыг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, туршлагатай байх;
 - 2.1.3 Пост-доктороор ажиллуулах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байх;
 - 2.1.4 WoS болон Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд 1-ээс доошгүй өгүүлэл нэгдүгээр зохиогч, эсвэл холбоо барих зохиогчоор хэвлүүлсэн байх;
 - 2.1.5 Нийгэм, хүмүүнлэгийн ухааны суралцагчдын хувьд Scopus-т бүртгэлтэй бүтээл болон SPI индекстэй хэвлэлийн газарт нэг сэдэвт бүтээл,

монографыг нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор хэвлүүлсэн байх зэрэг болно.

- 2.2. Пост-докторыг удирдан ажиллуулахад профессор, харьяалах нэгж нэмэлт шаардлагыг тусгайлан тавьж болно.



Гурав. Сонгон шалгаруулах

- 3.1. МУИС-ийн судалгааны нэгж нь дараагийн жилд пост-доктор ажиллуулах бол харгалзах орон тоо, холбогдох төсвийг хавсралт 1-т дурдсан хугацаанд төлөвлөнө.
- 3.2. СХН нь судалгааны нэгжид дараа жилийн 1-р сард багтаан пост-докторын удирдагчийн сонгон шалгаруулалт явуулах талаар мэдээллийг хүргүүлнэ.
- 3.3. Холбогдох нэгж дараа жил ажиллах пост-докторын орон тоо, төсвийн талаарх батлагдсан мэдээллийг СХН нэгтгэнэ.
- 3.4. Нэгтгэсэн мэдээллийг тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны дотор багтаан МУИС-ийн ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, орон тоог баталгаажуулна.
- 3.5. Сонгон шалгаруулалт нь удирдагч болон пост-докторын гэсэн хоёр үе шатаар явагдана.
- 3.6. Холбогдох нэгжид харьяалал бүхий профессор нь пост-доктор ажиллуулахад дараах материалыг ажлын 15 хоногийн дотор СХН-д ирүүлнэ. Үүнд:
- 3.6.1. Пост-доктор ажиллуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон өргөдөл;
- 3.6.2. Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн мэдээлэл;
- 3.6.3. Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө бүхий үр дүнгийн түлхүүр үзүүлэлт.
- 3.6.4. Салбарын эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар баталгаажсан бүтээлийн жагсаалт.
- 3.7. Судалгааны сэдэв, удирдагчийн судалгааны бүтээл, хэрэгжүүлж буй төслийн тоо, мөнгөн дүн, МУИС-ийн дотоод санхүүжилт бүхий төсөл болон ARC-ын төслийн гүйцэтгэл болон өргүй байдлыг харгалзан үнэлж, СХН-ийн оруулсан, ректорын тушаалаар батлагдсан ажлын хэсэг шалгаруулна.
- 3.8. Хоёр дахь шатанд СХН пост-докторыг сонгон шалгаруулах зар түгээн, зарласнаас хойш ажлын 15 хоногийн дотор материалыг хүлээн авна.
- 3.9. Пост-докторт бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- 3.9.1. Пост-доктороор ажиллах хүсэлт (Судалгааны ажлаар гаргасан ололт амжилт, үр дүн мөн докторын дараах судлаачаар ажиллах шалтгаан, хүсэл эрмэлзэл, ирээдүйн академик зорилго болон карьерт үзүүлэх нөлөөллийн /хэтийн төлөв/ талаар илэрхийлж бичих);
- 3.9.2. Төрийн албан хаагчийн анкет;
- 3.9.3. Докторын дипломын хуулбар /эх хувийг авчрах/; докторын зэргээ хамгаалсан ч дипломоо гардан аваагүй тохиолдолд диссертациа

амжилттай хамгаалсныг нотлох хамгаалуулах зөвлөлөөр баталгаажсан баримт бичиг, эсвэл түүнтэй дүйцэх нотолгоо;

3.9.4. Салбарын эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар баталгаажсан бүтээлийн жагсаалт;

3.9.5. Судалгааны ажлын төлөвлөгөө;

3.9.6. Судалгааны ажлыг удирдах МУИС-ийн удирдагч профессорын тодорхойлолт, эсвэл урилга;

3.9.7. Ажил эрхэлж буй бол ажлын газрын тодорхойлолт.

3.10. Ирүүлсэн материалд үндэслэн энэ журмын 3.7.-д дурдсан ажлын хэсэг сонгон шалгаруулалт явуулж, шийдвэрлэнэ.

3.11. Сонгон шалгаруулалтын шийдвэрт үндэслэн тухайн хичээлийн жилд ажиллах пост-докторын мэдээллийг ажлын 10 хоногт багтаан нэгтгэж пост-докторын харьяалагдах нэгж, удирдагч профессор, гүйцэтгэх ажлын чиглэл, тэтгэлгийн хэмжээ, эх үүсвэр, хугацааг холбогдох нэгжийн захирлын тушаалаар баталгаажуулна.

Дөрөв. Пост-доктор ажиллуулах

4.1. Пост-докторыг удирдан ажиллуулах судалгааны ажлын удирдагч нь шалгаруулалтад тэнцсэн пост-доктортой гүйцэтгэх судалгааны ажлын агуулга, хэмжээ, ажиллах хугацаа, тэтгэлэг, судалгааны ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх асуудлыг тусгасан гэрээг 3 хувь гүйцэтгэж СХН-д хүргүүлнэ.

4.2. МУИС-аас бусад байгууллагын тэтгэлгээр, эсвэл профессор өөрийн төсөл, хөтөлбөрөөс санхүүжүүлэн пост-доктор удирдан ажиллуулах тохиолдолд энэ журмын 3.9 дэх заалтад дурдсан дагуу материалыг бүрдүүлж гэрээг 3 хувь үйлдэж СХН-д хүргүүлнэ.

4.3. Пост-докторын удирдагч нь пост-докторыг удирдах хугацаандаа нэгээс илүүгүй МУИС-ийн тэтгэлэгтэй пост-доктор ажиллуулна.

4.4. МУИС-ийн тэтгэлгээр пост-доктор ажиллах тохиолдолд ахлах багшийн зэрэглэлийн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг СХН-ийн удирдлагаар хянуулсан явцын тайланд үндэслэн сар бүр олгоно.

4.5. МУИС-аас бусад байгууллагын тэтгэлгээр пост-доктор ажиллах тохиолдолд тэтгэлгийн хэмжээ болон хугацааг гэрээгээр зохицуулна.

4.6. Гэрээт ажлын үргэлжлэх хугацааг дараах байдлаар тогтооно. Үүнд:

4.6.1 Пост-докторыг ажлын бүтэн цагаар ажиллуулах ба гэрээт ажлын үргэлжлэх хугацаа 4 улирлаас ихгүй байна.

4.6.2 Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээт хэлбэрээр ажиллуулах тохиолдолд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу ажлын цагийн дээд хязгаарыг баримталж, үндсэн ажил олгогчийн хамт хяналт тавина.

4.7. Пост-доктор болон удирдагчийн эрх, үүрэг нь энэхүү журмын Хавсралт 2-т



дурдсан гэрээгээр зохицуулагдана.

- 4.8. Пост-доктор нь судалгааны ажлын удирдагчтай хамтран судалгааны ажлын төлөвлөгөө гарган, гэрээний хавсралт болгон мөрдөж ажиллана.
- 4.9. Пост-докторын удирдагч, холбогдох тэнхимийн эрхлэгчийн зөвшөөрлөөр өөрийн мэргэжлийн хүрээнд 3 хүртэлх багц цагийн хичээлийг нэмэлт цалингүй заана.



Тав. Хяналт ба үнэлгээ

- 5.1. Удирдагч нь пост-докторын судалгааны ажлын явц, үр дүнг хичээлийн жилийн улирал бүр дүгнэж, цаашид гэрээг үргэлжлүүлэх эсэх шийдвэрийг пост-доктор ажиллуулж буй судалгааны нэгжийн удирдлагад танилцуулна.
- 5.2. Пост-доктор ажиллуулж буй нэгж нь пост-доктор ажиллуулах шаардлага, эрэлт хэрэгцээг судлан тодорхойлох, шаардлагатай мэдээлэл өгөх болон ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах дэмжлэг үзүүлж, шууд удирдлагаар ханган ажиллана.
- 5.3. Пост-доктор ажиллуулсан нэгж нь пост-доктор ажиллуулсан талаарх тайлан, гэрээг үргэлжлүүлэх эсэх шийдвэрийн хамтаар улирал бүр СХН-д хүргүүлнэ.
- 5.4. Пост-докторын судалгааны ажлын үр дүнг дараах шалгуураар, судалгааны салбарын онцлогт тулгуурлан үнэлнэ. Үүнд:
- 5.4.1. Шинжлэх ухааны суурь салбаруудад WoS, эсвэл Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор хэвлүүлсэн нэгээс доошгүй өгүүлэл;
- 5.4.2. Инженер, хэрэглээний болон технологийн салбаруудад 5.4.1.-д дурдсан өгүүлэл, эсвэл Scopus-т бүртгэлтэй олон улсын хурлын бүтээлд нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор хэвлүүлсэн нэгээс доошгүй өгүүлэл, эсвэл патент, аж үйлдвэрт нэвтрүүлсэн технологи тус бүр 1-ийг МУИС-ийн нэр дээр бүртгүүлэх;
- 5.4.3. Нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбаруудын хувьд 5.4.1.-д дурдсан өгүүлэл, эсвэл Scopus-т бүртгэлтэй олон улсын хурлын бүтээлд нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор хэвлүүлсэн нэгээс доошгүй өгүүлэл, эсвэл Scopus болон SPI-д бүртгэлтэй монограф, номд 1 бүтээлийг нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор хэвлүүлэх.
- 5.5. Пост-доктор нь өөрийн судалгааны ажлын үр дүнг харьяалагдаж буй тэнхим болон нээлттэй семинарт илтгэх, суралцагчдад семинар явуулах, зөвлөгөө өгөх байдлаар түгээн дэлгэрүүлнэ.
- 5.6. Пост-доктор нь судалгааны ажлын үр дүн, гүйцэтгэлийн талаар улирал бүр харьяалагдах нэгжийн удирдлага, удирдагчид тайлагнаж, тайланг холбогдох нэгжид хүргүүлнэ.
- 5.7. Пост-доктор нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн пост-докторыг удирдан ажиллуулсан профессор, дэд профессор нь дахин 5 жилийн хугацаанд пост-доктор удирдан ажиллуулах эрхийг түдгэлзүүлнэ. Харин пост-докторын хувьд авсан тэтгэлэгийг эргүүлэн бүрэн төлүүлэх ба

СХН-ийн тогтоосоноор хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд пост-доктортой байгуулсан гэрээг 1 жилээр сунгаж, гэрээний биелэлтийг бүрэн хангуулж болно.



- 5.8. Пост-доктор ажиллуулсан гүйцэтгэлийн дүнг СХН нэгтгэн, ректорын зөвлөлд жил тутам тайлагнана.
- 5.9. Пост-доктор ажиллуулж буй судалгааны нэгж нь энэ журмын Хавсралт 1-т дурдсан үйл ажиллагааны зураглалыг мөрдлөг болгон ажиллана.

Зургаа. Гадаадын харьяат иргэнийг пост-доктороор ажиллуулах

- 6.1. Гадаадын харьяат иргэнийг МУИС-д пост-доктороор ажиллуулах үйл ажиллагаа нь энэхүү журам болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын иргэний хууль (359–368-р зүйл), Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг баримтална.
- 6.2. Гадаадын харьяат иргэнийг пост-доктороор ажиллуулахад тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, гэрээний эрх, үүрэг, судалгааны ажлын явц болон үр дүнг үнэлэх, хянах үйл ажиллагаа нь энэхүү журмын 2-5-р заалт болон Хавсралт 2-т тусгагдсан гурван талт гэрээний үндсэн дээр зохион байгуулагдана.
- 6.3. СХН нь гадаад судлаачтай гэрээ байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрөл болон оршин суух эрхийн асуудлаар МУИС-ийн холбогдох нэгж, төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Хавсралт 1. Пост-доктор ажиллуулах үйл ажиллагааны зураглал

№	Үйл ажиллагаа	Нэгжүүд				Баримт бичиг	Хугацаа /сараар/
		Судалгааны төв, хүрээлэн	Бүрэлдэхүүн болон салбар сургууль	СХН	Ректорын зөвлөл		
Төлөвлөх	1	Анхан шатны нэгж хуралдан, хэрэгцээ шаардлагаа жилээр тодорхойлж, орон тоо, төсвийг төлөвлөх	✓			Хүсэлт Хурлын протокол	IX.1-X.30
	2	Бие даасан нэгж бүрэлдэхүүн сургууль хуралдаж төлөвлөсөн орон тоо, төсвийн хүрээнд хүсэлтээ СХН -д хүргүүлэх	✓			Хүсэлт Хурлын протокол Албан тоот	
	3	Төсөвт тодотгол орох тохиолдолд СХН-д мэдээлэл хүргүүлэх, санал солилцох	✓			Албан тоот	XI.1- 30
	4	СХН нэгтгэл, дүгнэлт гаргаж, Ректорын зөвлөлд саналаа танилцуулах		✓		Албан мэдээлэл	
	5	Ректорын зөвлөл хэлэлцэн тухайн хичээлийн жилд МУИС-д ажиллах пост- докторын тоог батлах			✓	Хурлын шийдвэр	XII.1-20
Гүйцэтгэх	6	Мэдээлэл сонсож шаардлагатай тохиолдолд шинээр ажиллах пост- докторын тоог батлах					XII.20-31
	7	Хүсэлтийг шийдвэрлэсэн байдал, батлагдсан пост-докторын тооны талаар мэдээлэл гаргаж, нэгжүүдэд хүргэх		✓		Албан мэдээлэл	I.1-21
	8	Зар хүргэж, бүртгэл явуулах	✓	✓		Зар Маягтын дагуу бүртгэл	
	9	Пост-докторыг сонгон шалгаруулж гэрээ байгуулах	✓	✓		Сонгон шалгаруулалтын мэдээлэл	I.22-30
	9	Пост-докторын сонгон шалгаруулалтын мэдээлэл, тушаал гаргуулах, гуравласан гэрээ, пост- докторын бүртгэлийг СХН-д ирүүлэх	✓	✓		Хурлын протокол Тушаал Пост-докторын бүртгэл Гуравласан гэрээ 3% Ажлын төлөвлөгөө	



10	4	Нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл гаргах				✓		Мэдээллийн сан Ерөнхий мэдээлэл	II.1-10
11	5	Пост-докторыг удирдлагаар ханган ажиллуулах	✓	✓			Ажлын гүйцэтгэлийн мэдээлэл	Гэрээний хугацаанд	11.1-10
12	6	Пост-докторын ажлын явцыг үнэлж, дараагийн улиралд ажиллах эсэхийг шийдэх	✓	✓	✓		Маягтын дагуу ажлын явцын тайлан Маягтын дагуу үнэлгээ	Улирал бүр	
13	7	Пост-докторын ажлын улирлын үр дүнгийн талаар дүгнэлт тайлан гаргаж, СХУ-д хүргүүлэх	✓	✓			Маягтын дагуу ажлын гүйцэтгэлийн улирлын тайлан Маягтын дагуу дүгнэлт	Гэрээний дуусгавар хугацаагаар	
14	8	Нэгдсэн, тайлан үнэлэлт дүгнэлт, санал гаргаж, Ректорын зөвлөлд танилцуулах			✓		Албан мэдээлэл		
15	9	Тайлан, саналыг хэлэлцэж, шийдвэрлэх				✓	Хурлын мэдээлэл		



БАТЛАВ.

Гарын үсэг

Судалгааны нэгжийн захирал

Овог нэр

ПОСТ-ДОКТОР АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭ

202 . . . оны . . . сарын . . . -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Монгол Улсын Иргэний хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, МУИС-д пост-доктор ажиллуулах журмыг үндэслэн МУИС-д пост-доктор ажиллуулах энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын Их Сургуулийг төлөөлөн сургуулийн захирал [Захирлын нэр] (цаашид "Захиалагч" гэх), тус сургуулийн [нэгжийн нэр] тэнхимийн профессор овогтой (цаашид "Удирдагч" гэх), нөгөө талаас тоот регистрийн дугаартай сургуулийн [тэнхимийн нэр] пост-доктор овогтой (цаашид "Пост-доктор" гэх) нар харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

- 1.1 Захиалагч болон пост-доктор нь хамтран ажиллах, харилцан ашигтай байх, түншлэлийн зарчмыг баримтлан ажиллана.
- 1.2 Энэхүү гэрээгээр ажиллагч пост-доктор нь 202 . . . оны . . . дүгээр сарын . . . -ны өдрөөс эхлэн . . . сарын хугацаанд сургуулийн [тэнхимийн нэр] -д пост-докторын судалгааг хийнэ.
- 1.3 Пост-доктороор ажиллуулах тушаалын хуулбар, ажлын төлөвлөгөөг энэхүү гэрээнд хавсаргана.
- 1.4 Пост-докторын судалгааг төлөвлөгөөнд тусгасны дагуу ажлын өдрүүдэд 8 цагаар хийж гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллаж болно.

2. Захиалагч болон удирдагчийн эрх, хүлээх үүрэг

- 1.1 Пост-докторын судалгааны ажлын гүйцэтгэлийг шаардах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгааны ажлын тайланг хүлээн авах, гүйцэтгэлийг зохих ёсоор хангаж ажиллахыг шаардах эрхтэй.

- 
- 1.2 Пост-доктор нь гэрээгээр хүлээсэн ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, гүйцэтгэж буй ажил нь захиалагчийн шаардлага хангахгүй, нууцын холбогдолтой баримт бичиг задруулсан болон бусад буруутай үйлдлийн улмаас захиалагчид хохирол учруулсан бол хэдийд ч гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, өөрт учирсан хохирлоо бүрэн барагдуулахыг шаардах эрхтэй.
- 1.3 Ажил үүргийн хуваарь, сургуулийн дотоод дүрэм, журмыг танилцуулах, холбогдох зааварчилгааг өгөх зэргээр пост-докторыг удирдлагаар хангаж ажиллах үүрэгтэй.
- 1.4 Удирдагч профессорын зүгээс пост-докторын судалгааны ажлын явц, үр дүнг хичээлийн жилийн улирал бүр дүгнэж, цаашид гэрээг үргэлжлүүлэх эсэх шийдвэрийг захиалагчид танилцуулах үүрэгтэй.
- 1.5 Захиалагч болон удирдагч нь пост-докторт шаардлагатай мэдээлэл өгөх болон ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах дэмжлэг үзүүлж, шууд удирдлагаар ханган ажиллах үүрэгтэй.

3. Пост-докторын эрх, хүлээх үүрэг

- 3.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор хийж гүйцэтгэж, тэтгэлгийг тохиролцсон хугацаанд авахыг шаардах эрхтэй.
- 3.2 Гэрээнд заасан ажлын нөхцөл бололцоогоор хангахыг Захиалагчаас шаардах, захиалагч болон удирдагчийн буруугаас ажлыг гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажлыг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.
- 3.3 Энэ гэрээний Хавсралтад заасан судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу ажлыг тоо, чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, судалгааны чадавхаа байнга хөгжүүлэх бөгөөд ажлын гүйцэтгэлийг судалгааны үр дүнгээр баталгаажуулж, тайлагнах үүрэгтэй.
- 3.4 Өөрийн буруутай үйлдлийн улмаас захиалагчид учруулсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 3.5 Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй, биелүүлэх боломжгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд пост-доктор нь олгосон тэтгэлэгийг буцааж бүрэн төлөх үүрэгтэй. СХН-ийн тогтоосоноор хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд пост-доктортой байгуулсан гэрээг 1 жилээр сунгаж, гэрээний биелэлтийг бүрэн хангуулж болно.
- 3.6 Судалгааны явцад олж авсан нууцлалын зэрэглэлтэй холбоотой мэдээллийг захиалагч болон удирдагчийн зөвшөөрөлгүй гадагш дамжуулах, задруулахгүй байх үүрэгтэй.
- 3.7 Удирдагч шаардлагатай гэж үзвэл 3 хүртэлх багц цаг бүхий хичээлийг (лекц, семинар, лаб.) тухайн судалгааны ажилтай уялдуулан нэмэлт цалингүйгээр заана.
- 3.8 Пост-доктор нь өөрийн судалгааны ажлын үр дүнг мэргэжлийн тэнхимийн семинарт 1 удаа, тухайн салбарын семинарт 1 удаа хэлэлцүүлэх, суралцагчдад семинар явуулах, зөвлөгөө өгөх байдлаар хэлэлцүүлнэ.
- 3.9 Пост-доктор нь судалгааны ажлын үр дүн, гүйцэтгэлийн талаар сар бүрийн 20-ны дотор явцын тайлан гаргаж удирдагчаар баталгаажуулан СХН-д хүргүүлнэ.

- 3.10 Пост-доктор нь сар бүрийн судалгааны ажлын тайланг нэгтгэн улирлын эцэст захиалагч болон удирдагч профессортоо тайлагнана.
- 3.11 Пост-доктор нь гэрээг дүгнэх үед МУИС-ийн профессортой хамтарсан судалгааны үр дүн нь энэ журмын 5.4-д заасан дагуу биелүүлсэн (хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) байж болно) байна.
- 3.12 Гүйцэтгэгч төслийн үр дүнг хэвлэн нийтлүүлэх, мэдээлж түгээх, сурталчлахдаа МУИС-ийн санхүүжилтийн хүрээнд гүйцэтгэсэн болохыг хэвлүүлсэн бүтээлийн талархал бүлэгт дараах байдлаар тусгана. Үүнд: This work has been done within the funding of the National University of Mongolia.
- 3.13 Пост-докторын удирдагч профессорын зүгээс шаардлагатай гэж үзвэл их сургуулийн хэмжээнд зохион байгуулагдах цаг үеийн шинжтэй бусад ажилд оролцоно.



4. Санхүүжилт

- 4.1 Пост-доктор нь сард энэ журмын 4.4.-д дурдсан /бичгээр/ төгрөгийн тэтгэлэг авах ба тэтгэлэгийг сар бүрийн 25-ны өдөр олгоно.
- 4.2 Пост-доктор нь Монгол Улсын холбогдох хуульд заасан татвар, шимтгэлийг тухай бүр төлнө.

5. Бусад зүйл

- 5.1 Захиалагч гэрээний үүргийн биелэлтийг гэрээний хугацаанд дүгнэнэ.
- 5.2 Гэрээний хугацаа дууссанаар гэрээг дуусгавар болгоно.
- 5.3 Гэрээний биелэлтийг талууд харилцан дүгнэж, тэмдэглэл үйлдэж, гарын үсгээр баталгаажуулна.
- 5.4 Аль нэг тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай саналыг гаргах бол энэ тухайгаа 14 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 5.5 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг нөгөө талдаа 7 хоногийн өмнө бичгээр танилцуулж, харилцан тохиролцож, гарын үсэг зурж баталгаажуулан гэрээнд хавсаргаснаар үндсэн гэрээний нэгэн адил хүчинтэй байна.
- 5.6 Пост-доктор нь МУИС-ийн ашиг сонирхолд харшлах, нэр хүндийг унагах, хохирол учруулах аливаа үйлдэл хийсэн нь нотлогдвол энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцална.
- 5.7 Пост-доктор нь гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд цаашид МУИС-иас зохион байгуулах аливаа эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрүүдэд оролцуулахгүй.
- 5.8 Пост-доктор нь гэрээний хугацаанд аливаа ёс зүйн зөрчил гаргасан, бүтээл хуулбарласан, МУИС-ийн аливаа нэр хүндийг унагсан үйлдэл гаргасан нь нотлогдвол олгосон тэтгэлгийг буцаан бүрэн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргана.
- 5.9 Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 5.10 Энэхүү гэрээг гурван хувь үйлдэж, талууд нэг нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Удирдагчийн овог нэр

Хаяг:

Пост-докторын овог нэр

Хаяг:



Пост-доктор ажиллуулах гэрээний хавсралт

БАТЛАВ.

Гарын үсэг

Пост-докторын удирдагч

Нэр, албан тушаал

Ажлын төлөвлөгөө

ДД	Зорилго, зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн	Үр дүнгийн баталгаажилт	Нэмэлт тайлбар
1						
2						
3						
4						
5						

Боловсруулсан:

Гарын үсэг

Пост-докторын овог нэр

Огноо